



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 633

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Автотээврийн үндэсний төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын Дорноговь аймгийн Автотээврийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглагч байгууллагад давхар бүртгэгдсэн нийт 52,098,450.00 (тавин хоёр сая ерэн найман мянга дөрвөн зуун тавин) төгрөгийн балансын үнэ, 11,505,074.70 (арван нэгэн сая таван зуун таван мянга далан дөрвөн төгрөг далан мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. "Автотээврийн үндэсний төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал П.Дэлгэрнаран, Дорноговь аймгийн Автотээврийн төвийн дарга Б.Хүдэрболд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:


2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;


2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

 Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

 Б.ГАВАА

0002672

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн
...6.33... дугаар тогтоолын хавсралт

Дорноговь аймгийн Автотээврийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Хэм жих нэгж	Ашиглал тад орсон огноо	Тоо хэм жээ	Нэг бүрийн үнэ (төгрөгөөр)	Балансын үнэ (төгрөгөөр)	Хуриутлагдсан элэгдэл (төгрөгөөр)	Үлдэгдэл өртөг (төгрөгөөр)
1	Барилгын гаднах дулааны шугам /ган яндан Ф150х6/	ш	2009/04/01	1	52,098,450.00	52,098,450.00	11,505,074.70	40,593,375.30
				1		52,098,450.00	11,505,074.70	40,593,375.30
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН			1 (нэг)		52,098,450.00 (тавин хоёр сая ерэн найман мянга дөрвөн зуун тавин төгрөг)	11,505,074.70 (арван нэгэн сая таван зуун таван зуун таван мянга далан дөрвөн төгрөг далан мөнгө)	40,593,375.30 (дөчин сая таван зуун ерэн гурван мянга гурван зуун далан таван төгрөг гучин мөнгө)